



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/725

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Багш нарын байр, Болорын 27 айлын орон сууцны гадна талбайн засвар, тохижилт /Жаргалант сум/-ийн ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орсонтой холбогдуулан үүссэн нөхцөл байдалд дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

З.Өмиртай - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Түмэндэмбэрэл -Аймгийн Засаг Даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Д.Тогтохбаяр -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн


С.Бямбасүрэн -“Алтайн газрын хүч” ХХК-ний захирал

Д.Тэнгис -“Затус”ХХК-ний захирал

Нарийн бичгийн дарга: Б.Жамбалдорж -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2. Багш нарын байр, Болорын 27 айлын орон сууцны гадна талбайн засвар, тохижилт /Жаргалант сум/-ын ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орсонтой холбогдуулан үүссэн нөхцөл байдалд дүгнэлт гарган 2019 оны 11 дугаар сарын 11-ний өдрийн дотор багтаан танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /З.Өмиртай/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН